

# И-СКҮҮЛ ПРО-ГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

※Уг үйлчилгээг авахын өмнө сайтар үншиж танилцана уу!!!



\* \* \* Гэрээний Ерөнхий Агуулга \* \* \*

## 1-р ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1-р Хэсэг. Гэрээний Ерөнхий Нөхцөл

- 1.1 Уг гэрээ нь ХХК “АЛЬФА”-гийн эзэмшлийн И-СКҮҮЛ ПРО (цаашид “Сургалтын Төв” гэнэ) -гоос үзүүлэх онлаин хичээл (цаашид “үйлчилгээ” гэнэ) -ийг ашиглах гэрээний хэм хэмжээг тогтооно.
- 1.2 Үйлчилгээ авагч (цаашид “суралцагч” гэнэ) нь насанд хүрээгүй тохиолдолд түүнийг төлөөлж Сургалтын Төвтэй гэрээ хийх этгээд (цаашид “үйлчлүүлэгч” гэнэ) нь суралцагчийн асран хамгаалагч (цаашид “асран хамгаалагч” гэнэ) болно.
- 1.3 Суралцагч (эсвэл асран хамгаалагч) гэрээг хүлээн зөвшөөрч, уг гэрээнд гарын үсэг зурах, эсвэл тамга дарсанаар гэрээг хүчинтэйд тооцно.

## 2-р ЗҮЙЛ. ГЭРЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Сургалтын төвийн уг гэрээ өөрчлөлт хийгдэхгүй хатуу нөхцөлтэй.

## 3-р ЗҮЙЛ. ГЭРЭЭНИЙ ХЭЛЛЭГИЙН ТАЙЛБАР

Суралцагч гэдэг нь үйлчилгээг авч буй хувь хүн юм.

Асран хамгаалагч гэдэг нь насанд хүрээгүй суралцагчийн асран хамгаалагч юм.

Үйлчлүүлэгч гэдэг нь төлберийн чадвар бүхий сургалтын төвийн үйлчилгээг авагч хувь хүн юм.

Багш гэдэг нь сургалтын төвийн багш бөгөөд суралцагчид туршилтын хичээл, үндсэн хичээл, онцгой хичээл заах бүхий л багш юм.

## 4-р ЗҮЙЛ. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

1-р Хэсэг. Гэрээ хэрэгжих

- 1.1 Үйлчлүүлэгч үйлчилгээний гэрээнд гарын үсэг зурсанаар гэрээг хүчинтэйд тооцно. Ингэснээр, уг гэрээний агуулгыг бүрэн ойлгож зөвшөөрсөнд тооцогдоно.
- 1.2 Доорх нөхцөлд Сургалтын Төв үйлчлүүлэгчидтэй байгуулах гэрээнээс татгалзах эрхтэй.
  - Үйлчлүүлэгч мэдээллээ санаатай буруу өгсөн бол
  - Үйлчлүүлэгч өмнө нь сургалтын төвтэй хийсэн гэрээгээ зөрчиж, гэрээгээ цуцлуулж байсан түүхтэй бол

2-р Хэсэг. Гэрээний хүчинтэй хугацаа

Гэрээ байгуулсанаас эхлэн үйлчлүүлэгч гэрээг цуцлах саналаа 10-р Зүйлийн 1 Хэсэг-т заасны дагуу гаргах хүртэл уг гэрээ хүчинтэй. Гэрээг хүчээр хүчээр цуцлах талаарх 9 Зүйл, 1 Хэсэг-ийн нөхцөл байдал үүссэнээр гэрээний хугацааг мөн дууссанд тооцно.

3-р Хэсэг. Гэрээнд бүртгэлтэй мэдээллийн өөрчлөлт

Үйлчлүүлэгчийн анх өгсөн мэдээлэлэл өөрчлөлт гарвал, сургалтын төвд яаралтай холбогдон мэдээллээ өөрчлөх үүрэгтэй.

## 5-р ЗҮЙЛ. ҮЙЛЧИЛГЭЭ

1-р Хэсэг. Үйлчилгээний агуулга

1.1 Туршилтын хичээл

1.2 Үндсэн хичээл

1.3 Урамшууллын хичээл

2-р Хэсэг. Суралцагчтай холбоо тогтоох

Сургалтын төв нь

- Хичээлийн хуваарь
- Хичээлийн агуулга, хөтөлбөр
- Хичээлээс гадуурх үнэгүй ивэntийн талаарх мэдээлэл

Зэргийг сургалтын төвийн вэбсайт, SNS, и”мэйл хаягаар дамжуулан мэдээлнэ.

3-р Хэсэг. Асран хамгаалагч, суралцагчтай хийх уулзалт

Нэг курс хичээл дуусахаар суралцагчийн ахицын талаарх мэдээллийг сургалтын төвөөс асран хамгаалагч эсвэл суралцагчид мэдээлэх үүрэгтэй. Энэ уулзалт нэг үйлчлүүлэгчдэд 30 минут орчим үргэлжилнэ.

4-р Хэсэг. Хичээлийн хуваарь, үргэлжлэх хугацаа

Сургалтын төв болон суралцагч 2 талаас боломжтой цагаа тулган хичээлийн хуваарийг зохионо.

Нэг удаагийн хичээл 80 минут байна. Долоо хоногт 2 удаа орно. 4 долоо хоногийн нийт 8 хичээлийг 1 сарын үйлчилгээнд тооцно.



#### 5-р Хэсэг. Хичээлийн хуваарийн өөрчлөлт

Сургалтын төвийн зүгээс хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээлийн хуваарыт өөрчлөлт орвол өмнөх өдрийн 12 цаг хүртэл сурагчдад мэдээлэх үүрэгтэй. Түүнчлэн хуваарийн өөрчлөлтөөс үүсэх гомдол маргааныг бүрэн барагдуулна.

#### 6-р ЗҮЙЛ. ҮЙЛЧИЛГЭЭ ТӨЛБӨР

##### 1-р Хэсэг. Элсэлтийн хураамж

Сургалтын төвд шинээр элсэж байгаа тохиолдолд элсэлтийн хураамж 10,000 иен байна. (Тодорхой хугацаагаар зарлагдсан “элсэлтийн хураамж 0 иэн урамшуулал”-ийн үеэс бусад)

##### 2-р Хэсэг. Үйлчилгээний төлбөр

Үйлчилгээний төлбөр нь хичээлийн түвшнөөс шалтгаалж,

- N3～N4 түвшний япон хэлний шатгалтын нэг сарын хичээл · · · 10,000 иэн / 80 мин \* 8 удаа
- N1～N2 түвшний япон хэлний шатгалтын нэг сарын хичээл · · · 11,000 иэн / 80 мин \* 8 удаа

Тус тус байна. (нээлтийн болон бусад урамшууллаар өөрчлөлт гарч болно)

##### 3-р Хэсэг. Төлбөр төлөх өдөр

Төлбөр төлөх өдрийг сургалтын төв болон үйлчлүүлэгчид харилцан тохиролцно. Төлбөр төлөлтийн сүүлийн хугацаа тухайн сарын эхний хичээл эхлэхээс 1 өдрийн өмнө гэхэд төлөгдсөн байх үүрэгтэй.

#### 7-р ЗҮЙЛ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

Сургалтын төвд давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, түймэр, хар салхи, байгалийн гамшигт үзэгдэл, осол аваар, нийгмийг хамарсан үймээн) учирсан тохиолдолд үйлчлүүлэгчид яаралтай мэдэгдэн хэвийн үйл ажиллагаанд эргэн орсоноор үйлчилгээг үргэлжлүүлэх үүргийг хүлээнэ. Сурагцагч тал энэ үед үйлчилгээний үлдэгдэл төлбөрөө эргэн татах эрхтэй.

#### 8-р ЗҮЙЛ. ҮҮРГЭЭС ТАТГАЛЗАХ

##### 1-р Хэсэг. Үр дүнгээс татгалзах

Сургалтын төв нь суралцагч талд үр дүнг амлахаас татгалзах эрхтэй.

##### 2-р Хэсэг. Системийн алдаанаас татгалзах

Сургалтын төв нь стандартад нийцсан интернет, компьютер болон бусад зайлшгүй шаардлагатай төхөөрөмжүүдийг бэлдсэн. Гэсэн хэдий ч системийн алдаа, мэйлийн филтерээс үүсэх суралцагч талд очвол зохих мэдээлэл очоогүй үед сургалтын төв уг алдаанаас татгалзах эрхтэй.

##### 3-р Хэсэг. Багшийн зөвлөгөөнөөс үүдэлтэй маргаанаас татгалзах

Сургалтын төв нь багш нэг бүрийн сурагчдад өгч буй зөвлөгөөг хянах боломжгүй тул багшийн зөвлөгөөнөөс үүдэлтэй сурагч, асран хамгаалагч нарын гомдол зэргээс татгалзах эрхтэй.

#### 9-р ЗҮЙЛ. ГЭРЭЭГ ЗӨРЧИХ

##### 1-р Хэсэг. Гэрээг зөрчилд тооцож, гэрээг хүчээр цуцлах

Сургалтын төв нь үйлчлүүлэгчийн дараах үйлдлийг гэрээний зөрчилд тооцож гэрээг хүчээр цуцлах эрхтэй. Үүнд:

- Суралцагч, эсвэл асран хамгаалагч багштай хувийн холбоо тогтоож үйлчилгээг сургалтын төвөөс гадуур хувиар авахыг оролдсон бол
- Гэрээний 4 Зүйл 3-р хэсэгт заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй бол
- Суралцагчийн утас, и-мэйл хаяг, SNS хаяг руу холбоо барьсан боловч холбоо тогтоохгүй удах, хичээлийг 3-аас илүү дараалан тасалсан бол
- Гэрээг зөрчсөн бусад үйлдэл бий болсон бол

#### 10-р ЗҮЙЛ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

##### 1-р Хэсэг. Гэрээг цуцлах

Үйлчлүүлэгчийн зүгээс сургалтын төвд хандан үйлчилгээг зогсоож гэрээг цуцлах талаар санал хүргүүлэх эрхтэй. Саналыг хүргүүлсэнээс 2 долоо хоногийн дараа үйлчилгээг зогсоож гэрээг цуцална. Үйлчилгээний авч амжаагүй хэсгийн төлбөрийг Сургалтын төв үйлчлүүлэгчид буцаан олгох үүрэг хүлээнэ.

## **11-р ЗҮЙЛ. ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ**

1-р Хэсэг.Үйлчлүүлэгчийн мэдээлэл хамгаалах

Сургалтын төв үйлчлүүлэгчийн мэдээллийг 3-дагч талд дамжуулахгүй үүрэгтэй.



2-р Хэсэг.Үйлчлүүлэгчийн мэдээллийг ашиглах

Үндсэн хичээл, тусгай хичээлийн үер авсан зураг, видео зэргийг зөвхөн суралцагчийн зөвшөөрөлтэйгээр вэбсайт, SNS, рекламны хуудас дээр тавьна.

3-р Хэсэг. Багшийн ашиглах боломжтой хувийн мэдээлэл

Багш зөвхөн сурагчийн хичээлийн ахицыг дээшлүүлэх зорилгоор сураглцагчийн ажил мэргэжил, нас зэргийг мэдэх эрхтэй.

## **12-р ЗҮЙЛ. БУСАД**

Уг гэрээнд тусгагдаагүй үүссэн аливаа харилцааг ёс зүйд тулгуурлан 2 талдаа ашигтай хувилбараар шийднэ.

### **Сургалтын төвийг төлөөлж:**

Б. Хөлгөн

Гүйцэтгэх Захирал ХХК “Альфа”

Хаяг: Фүкүока муж, Кита Кюүшү хот, Яхата ниши дүүрэг, Такесүэ 2-14-2

Утас: 080-4041-5253

И-мэйл : info@academy-pro.jp

вэбхаяг : <http://www.academy-pro.jp/eschool-pro/>

※ Яаралтай бүс бол холбоо барихдаа SNS болон И-мэйл ашиглана уу!

### **Үйлчүүлэгч:**

.....